

## ОРОСЫН МАХНЫ ЗАХ ЗЭЭЛ БОЛОН МОНГОЛЫН ОРОЛЦОО

*М.Татьяна\**

Оросын махны зах зээл дотоодын үйлдвэрлэгчдээс гэхээс илүү гадаадын импортоос ихээхэн шалтгаалдаг юм. Махны зах зээл нь шувуу, гахай, үхэр, адуу, хонины мах болон тэдгээрийн бүтээгдэхүүний төрлөөс бүрдэнэ. Дотоодын үйлдвэрлэгчид нь шувуу, гахайн мах болон тэдгээрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээний талыг хүрэхгүй хувийг хангадаг ч, үхрийн махаар ихээхэн дутагддаг юм. Мах, махан бүтээгдэхүүний хэрэгцээ Оросын дотоодын үйлдвэрлэлийн өсөлтөөс хурдацтай байна. Энэ нь 2006 онд махны импорт 5 хувиар өссөнтэй холбоотой /тахианы махнаас бусад/ гэж ОХУ-ын Махны холбооны Зөвлөлийн дарга Мушег Мамиконян мэдээлжээ.

“Махны хэрэгцээ жил бүр 8%-иар өсч, энэ нь Оросын макро эдийн засгийн өсөлтөд нөлөөлж байна. Ойрын 3-5 жилд хэрэгцээ улам өсөх төлөвтэй” гэж М.Мамиконян хэлжээ. Эдийн засгийн байдал болон хүн амын амьдралын түвшин дээшилж буйг харгалзан махны хэрэгцээ өсөх төлөвтэй. Хэрэв 1 жилийн өсөлт нь 2006 оныхтой адил 5-7 хувьтай тэнцэх юм бол, 2009 онд дээр дурьдсан махны хэрэглээний түвшинд хүрч магадгүй.

Сүүлийн жилүүдэд дотоодын үйлдвэрлэл нь өсөх хандлага ажиглагдаж буй хэдий ч хүн амын хэрэгцээг бүрэн хангах боломжгүй байна. Импорт өссөн ч квотын нөхцлийн дагуу гаднаас мах, махан бүтээгдэхүүн орж ирдэг бөгөөд хөдөө аж ахуйн салбарын хөгжилд саад болохгүй, харин үйлдвэрлэгч, хэрэглэгч хоёрын хооронд тэнцвэрийг халгалахад тусалдаг гэж үздэг. Махны импортын квотыг Оросын Засгийн газар анх 2004 онд бий болгож, үүнд “түүхэн зарчим” дээр тулгуурлаж, Улсын гаалийн хорооны мэдээллээр сүүлийн 3 жилийн хугацаанд хийсэн импортыг авч үзсэн.

Тахианы махны квот нь гахай, үхрийн махны квотоос илүү үнэтэй нь тухайн үед тахианы үйлдвэр Орост илүү хөгжих хандлагатай байсантай холбоотой. Эдийн засгийн хөгжлийн яамны дэргэд Махны импортын мониторингийн зөвлөл байгуулж үүнийг судалжээ. Гэвч квот хуваасны дараа Оросын томоохон үйлдвэрлэгчид хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд ихээхэн эсэргүүцжээ. Учир нь квотод заасан газар зүйн нөхцөл тэдгээрийн эрх ашигт төдийлөн нийцээгүй бөгөөд “хаанаас импортлохоо өөрснөө мэдэхийг” шаарджээ.

Орос нь импортоор бүхий л төрлийн мах авдаг онцлогтой бөгөөд шувууны махны импортоор дэлхийд 1-р байр эзэлж,<sup>1</sup> энэ нь тус салбарт тэргүүлдэг АНУ-ын экспортын талыг дангаар худалдан авдаг.

\* М.Татьяна - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Бод малын 1 толгой өсгөхөд багаар болоход 3 жил хэрэгтэй байдаг бол харин гахай, шувууны аж ахуй байгуулаад хагас жилийн дараа эхний ашигаа олж болдог. Махны зах зээл нь гадаадын хөрөнгө ороогүй ганц салбар бөгөөд тэдгээр нь харин бүтээгдэхүүнээ борлуулах гэж Оросын зах зээлийг сонирхдог юм.

Дэлхийн махны зах зээлийн томоохон экспортлогч-орнуудыг авч үзвэл, шувууны махны үйлдвэрийн салбарт АНУ тэргүүлж дэлхийн экспортын 35%-ийг эзэлдэг, мөн Канад, ЕХ, Голланд, Өмнөд Америк, Бразил, Тайланд ордог. Гэвч “тахианы ханиадны өвчин”-ий улмаас 2006 онд экспорт эрс буурч байснаа эргээд өссөн. Мөн Европ, Ойрхи Дорнодод тахианы махны хэрэгцээ өсөж байгаа юм.

Гахайн махны хувьд, Хойд Америк, Европын орнууд нийт дэлхийн экспортын 2/3 хувийг эзэлж, Хятад, Бразил тэргүүлдэг. Харин сүүлийн үед Вьетнам, Филиппинд гахайн махны хэрэгцээ ихсэж, дотоодын үйлдвэрлэл өсөж байна. Үр тарианы ургац сайтай орнуудад гахайн махны үйлдвэрлэл хөгждөг.

Үхрийн махны салбарт Бразил, АНУ хоёр тэргүүлдэг. Импортлогч орнууд -Япон, Хятад, Өмнөд Солонгос. Гэтэл сүүлийн жилүүдэд АНУ хямд үнэтэй үхрийн мах импортлож авч байсан нь бод малын сангаа сэргээж байгаатай холбоотой. Бод малыг үржүүлэх нь тахиа, гахайг бодвол, олон жил шаарддаг. Дэлхийд АНУ, Австрали, Шинэ Зеланд зэрэг орнууд үхрийн мах экспортлодог.

Австрали, Шинэ Зеланд хоёр хонины махны томоохон экспортлогч орнууд бөгөөд дэлхийн нийлүүлэлтийн 80%-ийг эзэлдэг. 2004 оноос эхлэн хонины махны нийлүүлэлт ихэссэн учир 2005 онд хонины махны үнэ 16%-иар буурч байсан. Мөн Австрали, Аргентин, Бразил, Хятад, Энэтхэг, Иран, Пакистан зэрэг орнууд экспортлодог. Импортлогч орнууд нь Канад, Хятад, Япон, Мексик, АНУ юм.

Хэрэглээний хувьд гэвэл, 2006 онд тахианы ханиадны өвчний улмаас тахианы махны хэрэглээ дэлхийд өмнөх үеийхээс нийтдээ бага байсан. Дэлхийн дундаж үзүүлэлтээр 1 хүн жилд 43 кг тахианы мах хэрэглэх ёстой байдаг. Ерөнхийдөө баян, ядуу орнуудын хүн амын хэрэглээний ялгаа аажмаар арилж байгаа бөгөөд хөгжиж буй орнуудын хүн ам нь тахианы махны 60%-ийг хэрэглэж байна.

2004 оноос бүх төрлийн махны экспортоор Бразил дэлхийд 1-р байр эзэлж АНУ-аас түрүүлжээ.<sup>2</sup>

Тахианы махны томоохон импортлогч - ОХУ-ын дотоодын үйлдвэр 1 жилд 15%-иар өсч, сүүлийн жилүүдэд анх удаа гахайн махны үйлдвэр 4%-иар өссөн. 2006 онд анх удаа Оросын махны зах зээл дээр хамгийн чухал үйл явдал болж түүнийг оросууд “түүхэн эргэлт” болсон

гэж онцлон тэмдэглэжээ. М.Мамиконяны тэмдэглэснээр, Оросын хөдөө аж ахуйн салбарт эдгээр өөрчлөлтүүд өндөр ач холбогдолтой ажээ.<sup>3</sup>

Гэвч 2006 оны эхний хагаст үхрийн махны үйлдвэрлэл Орост буурч, импортоор их хэмжээгээр орох болжээ.<sup>4</sup> ОХУ-ын Улсын статистикийн газрын /Госкомстат/ мэдээлснээр, 2006 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар 2005 оныхтой харьцуулбал, шувууны тоо - 7, 4%, гахайн тоо - 10,2%-иар тус тус өсч, бод малын тоо 6,7%-иар буурсан.

Мөн хугацаанд шувууны махны үйлдвэрлэл амьдын жингээр 19,1%, гахайн махны – 8,9%-иар тус тус өсчээ. Харин 2006 оны эхний хагаст үхрийн махны үйлдвэрлэл 7,9%-иар буурчээ.

Үүний шалтгаан юунд байна вэ гэвэл, 2005 онд ОХУ-ын Хөдөө аж ахуйн Яамнаас гахайн аж ахуйг дэмжих төслийг боловсруулж, банкны хөнгөлөлттэй зээл олгохыг зөвшөөрсөн юм. Иймээс Оросын томоохон компаниуд гахай, шувууны үйлдвэрлэлд хөрөнгө оруулж эхэлсэн.

Оросын Хөдөө аж ахуйн маркетингийн хүрээлэнгийн /Институт Аграрного Маркетинга/ мэдээлснээр 2006 оны эхний хагаст /2005 оны мөн хугацаатай харьцуулбал/ махны түүхий эдийн нийт нөөц нь 16,2%-иар өссөн нь үйлдвэрлэл болон импортын өсөлтөөс шалтгаалжээ. Мөн хугацаанд махны импорт 3,8%-иар өссөн юм. Гахайн махны нөөц 43,4%, үйлдвэрлэл 16,2%, импорт 35,5% тус тус өссөн. Шувууны махны нөөц 19,8%, үйлдвэрлэл 20,3%, импорт 6%-иар тус тус буурсан. Энэ хугацаанд Хөдөө аж ахуйн хяналтын алба /Россельхознадзор/ нь шувууны мах, тэдгээрийн бүтээгдэхүүнийг бүрэн хориглосонтой холбоотой.

Үхрийн махны нөөц 13,6%, үйлдвэрлэл 9%-иар буурч, импорт дөнгөж 0,7% өссөн. 2006 оноос 1 хүнд ногдох хэрэглээ 5,9%-иар өссөн. Харин үхрийн махны хэрэглээ мөн хугацаанд 10%-иар буурч, гахайн махны хэрэглээ 20%, шувууны махны хэрэглээ 6,6 % тус тус өссөн.

2005 оныхтой харьцуулбал, 2006 онд махны зах зээлийн багтаамж 4,4% өсөж, гахайн махны зах зээлийн багтаамж 20%, шувууны махны зах зээлийн багтаамж 9% тус тус өсөж, харин үхрийн махны хэрэглээ 9%-иар буурсан байна. Махны зах зээлийн үнийн мониторингийн үр дүнд 2006 оны эхний хагаст үхрийн махны зах зээл дээр үхрийн хагас гулуузын үнэ 14,9%-иар өсч, дотоодын үхрийн махны хагас гулууз 10,5%, импортын хагас гулууз 6%-иар тус тус өссөн. Орост үхрийн гулуузын үнэ дунджаар 10,3%-иар өссөн.

Дотоодын үйлдвэрлэлийн гахайн махны хагас гулууз үнэ 5,6%-иар өсч, трейдерүүдийн үнэ 7,9%, импортын махны хагас гулууз 7,5% тус тус өссөн. Гахайн хагас гулууз дундаж 7,1%-иар өссөн. Шувууны махны үнэ дунджаар 4,9%-иар өссөн. Дотоодын үйлдвэрлэлийн махны трейдерүүдийн үнэ 11,5%-иар буурч, импортын 11,4%-иар буурсан. Шувууны мах дунджаар 9,3%-иар буурсан.

“Хөдөө аж ахуй-үйлдвэрлэлийн комплексыг хөгжүүлэх” нэртэй үндэсний төслийн дагуу махны үйлдвэрлэл 2007 онд 10% өссөн гэж ХААЯ мэдээлсэн байна. ХААЯ-ны сайд Алексей Гордеевын хэлснээр, гахайн, шувууны махны үйлдвэрлэл өсч дутагдал ихтэй бөгөөд үйлдвэрлэлийн хаягдал нь экологийн тэнцвэрийг алдагдуулах, махны боловсруулалт, савлалт муу байна гэж хэлжээ.<sup>5</sup>

“Хөдөө аж ахуйн комплексыг хөгжүүлэх” /”Развитие АПК”/ төсөл хэрэгжиж эхэлснээр энэ чиглэлийн томоохон бизнесийн сонирхол шинээр болж Вертикально интегрированные холдинги (ВИХ)-ууд бий болж, бүсүүдийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг худалдан авч, хоорондоо хувааж эхэлсэн. Эдгээр нь гахайн аж ахуйд ихээхэн хөрөнгө оруулж цаашид энэ салбар хичнээн хөрөнгө шаардах болно гэж үздэг. Экологийн асуудал гарахад цэвэршүүлэлтийн байгууламжид олон сая долларын хөрөнгө оруулах шаардлагатай болох юм. Гахайг зөвхөн үржүүлэх биш, нядалгааны дараа ариун цэвэрлэгээний ажил зайлшгүй хийх шаардлагатай. Гахайны аж ахуй олон ч гэсэн, цэвэршүүлэлтийн үйлдвэрүүд Орост маш цөөн байгаа юм.

Мөн мах боловсруулдаг компаниуд нь импортын түүхий эдээс дотоодын үйлдвэрийн хагас гулуузд шилжих дургүй, импортын мах авах дуртай байна.

Махны үйлдвэрлэл нь мал үржүүлэх, нядлах үйл явц, ариун цэврийн систем, гулуузыг хуваах, задлах, боловсруулах үе шатаас бүрддэг боловч, Орост эхний болон сүүлийн элементүүд байна гэж үздэг юм.

Мөн мах боловсруулалтын зах зээл нь “премиум” /дээд чанарын бүтээгдэхүүн/ нөхцлөөр сүүлийн хэдхэн жил ажиллаж байгаа бөгөөд одоогоор тодорхой ангилал Орост хараахан батлагдаагүй байна. Ийм байдлыг ашиглан махны үйлдвэрлэгчид чанар муутай махаар хийсэн өөрийн бүтээгдэхүүнээ “премиум” гэж нэрлэж сурталчилдаг байна. Хэрэглэгчдэд ямар чанарын махаар хийсэн бүтээгдэхүүн гэдгийг мэдэхэд бэрх, учир нь өмнө Орост шар буурцаг, үнэртүүлэгч, трансген гэсэн элементүүд хэрэглэгддэггүй байсан учир тодорхой хууль батлагдаагүй байгааг олон үйлдвэрлэгчид ашиглан бүтээгдэхүүндээ үүний орцыг тодорхой бичихгүйгээр “премиум” бүтээгдэхүүн гэж худалдаалж байна. Харин одоогоор Орост үе үе махны үйлдвэрүүдийг шалгаж торгуулийн арга хэмжээ авснаар асуудал дуусдаг. Нөгөө талаас, Барууны компаниудын бүтээгдэхүүн Оросын бүтээгдэхүүнээс үйлдвэрлэлийн чанараараа илүү байгаа юм.

Хөдөө аж ахуйн маркетингийн институтээс<sup>6</sup> 2007 оны 10 дугаар сард хийсэн махан консервын судалгааны үр дүнг 2004-2006 онд авч үзвэл, 2005 онд өмнөх жилтэй харьцуулбал 21,4%-иар өсч, харин 2006 онд 5,1%-иар эргээд буурч, нийт 2 жилийн хугацаанд 15,2%-иар өссөн.

Нухашны үйлдвэр 82,4%, тушонк болон махан консервын үйлдвэр 6,1% тус тус өсчээ. Махны консервын үйлдвэрлэлээр 2006 оны байдлаар, Калининград муж 22,6%, Москва муж 13,1% тус тус эзэлж оросын нийт үйлдвэрлэлд тэргүүлэх байр суурь эзэлдэг. Мөн нухашны үйлдвэрлэлээс гадна хүүхдэд зориулсан махан консерв ирээдүйтэй гэж тооцогддог бөгөөд 2 жилийн хугацаанд Краснодар, Москва, Новгород мужууд тэргүүлэх бөгөөд тус үйлдвэрлэл нь нийтдээ 33,5%-иар өсчээ. Хүүхдэд зориулсан махан консервын үйлдвэрлэл өсч, импортын нийлүүлэлт дагаад өссөн. Импорт нь 2004 онд 12%, 2006 онд 26% болж өсчээ.

Махны тушонк болон консервын хэрэгцээ эрс багасаж, харин Госрезерв, Онцгой байдлын яам, Батлах хамгаалах яам, Дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар зэрэг байгууллагууд нийт улсын үйлдвэрлэлийн 60%-ийг эзэлж, харин 30%-ийг Баруун-Хойд, Алс Дорнодын хүн ам хоолондоо хэрэглэдэг юм. Сүүлийн жилүүдэд махны консервын бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжихгүй байгаа шалтгаан нь хүн амын цалин сайжирч, хиам, утсан мах, махан ороомог авдаг болжээ.

2007 оны 9-р сарын Оросын мах, махан бүтээгдэхүүний зах зээлийн байдлаар, үхрийн махны зах зээл: бод малын тоо 8 сартай харьцуулбал, нийт 0,3% багасаж, Холбооны Төв тойрогт 7,5%, Алс Дорнодын Холбооны тойрогт 7,3%-иар буурчээ. Амьд малын тоо 13,8% өсөж, харин бод малын махны үйлдвэрлэл өсөж, Холбооны Өмнөд тойрогт 20,5% хүрсэн. Боловсруулах үйлдвэрүүд үхрийн дотоодын махны боловсруулалтыг 1,1% багасгаж, харин импортын махны боловсруулалт 35,7% өссөн. Үхрийн махны хэрэгцээ эрс нэмэгдсэн учир үхрийн махны зах зээлийн багтаамж 20%-иар өссөн байна. Амьд малын үнэ 2007 оны 11-р сард 1,5%-иар өсч, үхрийн махны хагас гузуулны үнэ 10-р сарын 15-наас 11-р сарын 15 хугацаанд 0,6%-иар тус тус өсчээ. Үхрийн цул мах 0,7%-иар өссөн.

Гахайн махны зах зээл: гахайн тоо 2,4% өсч, нядалгаа 5,7% буурч, боловсруулах үйлдвэрүүд ажлаа 6% багасгаж, харин импортын мах 9,7%-иар Бразил, Дани, Германаас өссөн. Эдгээр орнууд нь Оросын импортын 58% эзэлдэг. Иймээс гахайн махны эргэлт 6,7%-иар буурсан. Гахайн махны хэрэглээ нийтдээ 1,75% буурч, зах зээлийн багтаамж нь 2,8% буурсан. 2007 оны 11 сарын 15-ны өдрийн байдлаар гахайн хагас гулуузын үнэ 0,5% өсч, цул мах 0,7% тус тус өсчээ.

Шувууны махны зах зээл: шувууны тоо 6,6% өсч, нядалгаа 1,3% буурсан. Боловсруулах үйлдвэрүүд ажлаа 1,1% багасгаж, харин импорт 25,1% буурсан. Санкт-Петербург, Москва, Калининградын муж Оросын импортын 86% эзэлдэг. Шувууны мах, импорт багасснаар шувууны махны

зах зээлийн нөөц 15,1% буурч, зах зээлийн багтаамж нь 2% буурсан. 1 гулуузны үнэ 0,4%, цул мах 0,7%, тахианы мөч 1,1% тус тус өсчээ.

БН Хальмаг Тангч Улсын Ерөнхийлөгч Кирсан Илюмжинов нь Хальмагын хөдөө аж ахуйн салбар дээр үндэслэн “Оросын махны тойрог” байгуулах тухай саналаа В.Путинтэй Кремльд уулзах үеэр дэвшүүлжээ. Тэрбээр өмнө бод малын тоо 7,5 сая толгой хүрдэг байсан бол, одоо 350 мянга болон буурч, түүний хагас нь хальмаг үүлдрийн мал гэж онцлон тэмдэглэжээ.<sup>7</sup>

2008 оны 3-р сард Оросын Махны Холбооны Ерөнхийлөгч Мушер Мамиконяны хэснээр, Орос нь дэлхийн махны зах зээл дээр байр сууриа бэхжүүлэх бүрэн бололцоотой гэж тэмдэглэжээ. Сүүлийн 2 жилийн хугацаанд “Хөдөө аж ахуйн комплексыг хөгжүүлэх” тэргүүлэх үндэсний төслийн хүрээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл хөгжиж, махны үйлдвэрлэл 14%-иар өсчээ. Оросын 1 жилийн махны эргэлт нь 5,5 сая тоннд хүрсэн байна. Тус үндэсний төсөл нь Улсын хөтөлбөр болон хувирч, цаашид махны үйлдвэрлэлийг хөгжүүлэх болно. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд тээвэрлэлтийн асуудлыг шийдэх нь юунаас чухал байна гэж тэрээр тэмдэглэжээ. Тээвэрлэлтээс болж Оросын үйлдвэрүүд чанараар сайн үндэсний түүхий эд биш, импортын мах хэрэглэж байна. Мөн мал нядлах, түүхий эдийг боловсруулах салбарт Оросын махны үйлдвэрлэл хоцорч байна. Харин хэрэгжиж эхэлсэн Улсын хөтөлбөрт нядалгааны болон боловсруулах үйлдвэрийн барилгын хөрөнгө төсөвт оржээ. Ойрын хугацаанд том болон жижиг нядалгааны үйлдвэрүүд баригдаж, Алтай болон Хальмагт илүү хэрэгцээтэй байхыг тэмдэглэжээ.<sup>8</sup> Барууны технологи Орост өргөн хэрэглэж буйг М.Мамиконян нь хүлээн зөвшөөрч, цаашид Барууны хөгжсөн технологи нь тогтвортой бөгөөд ашигтай байхыг тэмдэглэжээ. Харин нядалгааны ажилчид, боловсруулагчид болон махны салбарын ажилчид дутагдалтай. Оросын хүн амыг уурагаар хангах ажлыг шувууны болон гахайн аж ахуйнууд амжилттай биелүүлж байна гэж тэмдэглэжээ. Ерөнхийдөө Орост 1 хүний 1 жилийн махны хэрэглээ эмч нарын зөвлөдөг 75-80 кг-д хэмжээнд дөхөж 65 кг болжээ. Мөн бод малын тоо өсөхөөс гадна, саалийн хэмжээ дагаад өссөн. Харин махны төрлийн бод малын тоо тийм ч сайн өсөөгүй байна гэж М.Мамиконян тэмдэглэжээ.

### Дүгнэлт

ОХУ нь махны томоохон импортлогч орны хувьд 2004 оноос эхлэн импортын квотын системд шилжсэн юм. Үүнд “түүхэн зарчим”-ыг баримтласан бөгөөд Монголын тухай тодорхой мэдээлэл алга байна. Зөвлөлтийн үед Монголоос мах их хэмжээгээр Орост нийлүүлж, Сибирийн махны үйлдвэрүүдийг хангадаг байсан түүхтэй. Үүний зориулалтаар ч Улаан-Үд хотод мах боловсруулах үйлдвэр байгуулж томоохон

үйлдвэрлэгчдийн тоонд ордог байсан. Орос-Монголын Засгийн газар хоорондын комиссын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын 2001 оны 7-р сард Улаанбаатар хотноо болсон 2 дугаар хуралдаан дээр Увс аймагт жижиг оврын мах боловруулах үйлдвэр барих тухай хэлэлцэж байсан удаатай. 2004 оны 4-р сард Улаанбаатар хотноо болсон тус дэд комиссын 4 дүгээр хуралдаан дээр Монголоос махны нийлүүлэлтийг сэргээх тухай хэлэлцсэн. 2007 оны 4-р сарын 27-нд Эрхүү хотноо болж өнгөрсөн 7 дугаар хуралдаан дээр 2000-2006 онд Монголоос Эрхүү муж нийт 5,4 сая ам.долларын мах импортлож, цаашид өсөх хандлагатайг онцлон тэмдэглэжээ.

ОХУ-ын томоохон зах зээл дээр Монголын экологийн цэвэр бүтээгдэхүүн болох махны хэрэгцээ маш их байгаа хэдий ч энэ нь хүнд сурталтай тулгардаг. Сибирийн махны чиглэлээр ажилладаг үйлдвэр, компаниуд импортлох гэхээр махны квотын бэрхшээлтэй тулгардаг. Сибирийн хэрэгцээнд Монголоос мах нийлүүлэхийн тулд Москвагаас зөвшөөрөл авах ёстой байдаг.

Иймээс цаашид Бүс нутаг, хил орчмын дэд комиссын хүрээнд олон асуудал шийдлээ олохын тулд хамтын ажиллагааны механизмыг өөрчлөх хэрэгтэй юм.

### ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Номер 191 от 08-10-94 Американцы проводят разведку боем. Визит американских экспортеров мяса птиц.  
<http://www.kommersant.ru/doc.aspx?DocsID=91910>
2. Источник: К. Аналитическая группа Крестьянских ведомостей.  
[http://www.mosprod.ru/ru/press/news\\_agencies/smi/200612151624-6739.htm](http://www.mosprod.ru/ru/press/news_agencies/smi/200612151624-6739.htm)
3. Мясной рынок: исторический перелом.20.10.2006  
<http://www.optifood.ru/analytics/article/147/2299.php>
4. Источник: К Ситуация на Российском мясном рынке в 1-ом полугодии 2006 года.  
<http://www.optifood.ru/analytics/article/147/2515.php>
5. Импорт говядины в 2007г. вырастет на 40%, заявил недавно министр сельского хозяйства Алексей Гордеев.
6. Российский рынок мясных консервов: текущее состояние и перспективы развития до 2012 г. 30.10.2007  
<http://foodretail.ru/news?mDate=31.10.2007>
7. ПРЕЗИДЕНТ КАЛМЫКИЙ ПРЕДЛАГАЕТ СОЗДАТЬ «МЯСНОЙ ПОЯС РОССИИ» Вторник, 08 августа 2006 года  
<http://www.rian.ru/economy/20060808/52383636.html>
8. Россия может стать экспортером говядины.  
<http://www.meatbranch.com/news/view/1654.html>